

## САНАМЖ

Хэрэв зорчигч нь иргэний агаарын тээврийн үйлчилгээний тухай Варшавын конвенц болон Монреалийн конвенцийг мөрдлөг болгодог улс орон руу зорчих ба дайран өнгөрөх тохиолдолд уг конвенцүүд нь зорчигчийн амь нас, эрүүл мэнд түүнчлэн тээшинд хохирол учрахад тээвэрлэгчийн хүлээх хариуцлагыг дийлэнх тохиолдолд хязгаарладаг. Та “Тээш тээвэрлэлтийн хариуцлагыг хязгаарлах тухай зорчигчдод өгөх санамж” болон “Тээш тээвэрлэлтийн хариуцлагыг хязгаарлах тухай санамж” зэрэгтэй танилцана уу.

### ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

1. Энэхүү гэрээнд дурьдагдсан зарим нэр томъёонууд нь дараах утгыг илэрхийлнэ. “Тийз” гэдэг нь зорчигчид олгосон энэхүү тийз бөгөөд тээвэрлэгч байгууллага, зорчигч хоёрын хооронд хийсэн тээвэрлэлтийн гэрээ юм. Электрон тийзийн тохиолдолд тийз болон ачааны баримтыг хэлнэ. “Тээвэрлэгч” гэдэг нь энэ гэрээ ёсоор зорчигч, түүний тээшийг тээвэрлэж байгаа буюу тухайн тээвэрлэлттэй холбогдох бусад үйлчилгээг гүйцэтгэж буй агаарын тээврийн байгууллагуудыг хэлнэ. “Электрон тийз” гэдэгт Тээвэрлэгчээс зорчигчид олгосон аяллын маршрут, баримт, мөн суудлын тасалбар орно. “Варшавын конвенц” гэдэг нь Варшав хотноо 1929 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурж, мөн 1955 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Гааг хотноо гарын үсэг зурсан протоколоор өөрчлөлт оруулсан олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмын тухай конвенц гэж ойлгоно. “Монреалийн конвенц” гэж 1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Монреаль хотноо гарын үсэг зурсан олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмын тухай конвенцийг хэлнэ.
2. Энэхүү гэрээ ёсоор гүйцэтгэж буй Тээвэрлэлт нь Конвенцийн дагуу “олон улсын тээвэрлэлт” биш болох нь тодорхойлогдоогүй бол Варшавын конвенц, Монреалийн конвенцоор батлагдсан тээш тээвэрлэлтийн хариуцлагыг хязгаарлах журам үйлчилнэ. Орон нутгийн нислэгт компанийн бүх хариуцлагыг Монгол Улсын холбогдох хуулийн заалтаар зохицуулагдана.
3. Дурдсан журамд харшлахгүй тул энэхүү гэрээгээр гүйцэтгэж буй тээвэрлэлт, тээвэрлэгчийн зүгээс үзүүлж буй бусад үйлчилгээ нь тус тийзэнд тодорхойлогдсон заалт; хэрэглэж буй хууль (конвенцийг хэрэглэх талаарх дотоодын хуулийг оролцуулан); засгийн газрын тогтоол захирамж, мөрдөж буй тариф; гэрээний нөхцөл болон түүнд хамаарах журамд (тээвэрлэгчийн аль ч салбараас мэдэх боломжтой) тус тус захирагдана.
4. Тээвэрлэгчийн нэрийг тийзэнд товчлон бичиж болно. Бүтэн нэр, түүний товчлол нь тарифын лавлах, тээврийн нөхцөл, зохих тээвэрлэгчийн цагийн хуваарьт заагдана. Тийзэнд тээвэрлэгчийн хаяг нь аялал эхэлсэн нисэх буудлын нэр байх ба тээвэрлэгчийн товчилсон нэрийн эсрэг талд тэмдэглэгдсэн байна. Зөвшөөрөгдсөн зогсоолууд гэдэг нь тийз эсвэл нислэгийн цагийн хуваарьт заагдсан аяллын чиглэлийн дагуу байх буудлуудыг хамааруулна. Энэхүү гэрээгээр хэд хэдэн тээвэрлэгчээр дамжигдан гүйцэтгэгдэж буй тээвэрлэлтийг нэг тээвэрлэлт гэж үзнэ.
5. Бусад тээвэрлэгчийн аяллын тийз бичиж буй агаарын тээврийн байгууллага нь түүний төлөөлөгч болно.
6. Тээвэрлэгчийн хүлээх хариуцлагыг хязгаарлах болон үгүйсгэх талууд нь тээвэрлэгчийн төлөөлөгч, ажилтан, мөн тэдгээрээр дамжуулан тээвэрлэлтийг явуулж буй агаарын хөлгийг эзэмшигч бүх этгээдэд хамаарна.
7. Бүртгэгдсэн тээшинд тээшний зүүлт олгоно. Олон улсын нислэгт тээш гэмтсэн тохиолдолд зорчигч нь тээшээ хүлээн авснаас долоо хоногийн дотор тээвэрлэгчид бичгээр гомдол гаргах ёстой. Тээш саатсан тохиолдолд тээшийг тээвэрлэсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гомдол гаргаж болно.
8. Энэхүү тийз нь тээвэрлэгчийн тариф, тээвэрлэлтийн нөхцөл буюу зохих журамд өөрөөр заагаагүй бол тийзний хүчинтэй байх хугацаа нь олгосон өдрөөс хойш 1 жил хүчинтэй байна. Тухайн гэрээгээр гүйцэтгэж буй тээвэрлэлтийн тариф нь тээвэрлэлт эхлэхээс өмнө өөрчлөгдөж болно. Зохих төлбөрийг төлөөгүй тохиолдолд Тээвэрлэгч нь тээвэрлэлтийг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.
9. Тээвэрлэгч нь зорчигч болон тээшийг хугацаанд нь тээвэрлэх талаар өөрөөсөө хамаарах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй. Нислэгийн хуваарь болон бусад баримт бичигт заасан цаг хугацааны талаар Тээвэрлэгч баталгаа өгөхгүй ба энэхүү гэрээний бүрэлдэхүүн хэсэг болохгүй. Шаардлага гарвал тээвэрлэгч нь урьдчилан мэдэгдэхгүйгээр зорчигчдыг өөр тээвэрлэгчид шилжүүлэх, онгоцыг солих, тийзэнд заагдсан буух газрыг өөрчлөх буюу хүчингүй болгож болно. Нислэгийн хуваарь зорчигчдод урьдчилан мэдэгдэхгүйгээр өөрчлөгдөж болно. Тээвэрлэгч нь угтвар аялалаар хангах талаар хариуцлага хүлээхгүй.
10. Зорчигч нь нислэгтэй холбогдолтойгоор засгийн газраас тавьсан бүхий л шаардлагыг биелүүлэх, хилээр орж гарахад шаардлагатай бичиг баримтаа үзүүлэх, тээвэрлэгчээс тогтоож өгсөн хугацаанд нисэх буудалд хүрэлцэн ирэх, хэрэв ийм хугацаа тогтоогдоогүй бол нислэгийн өмнөх бэлтгэл хангахад бүрэн хүрэлцэхүйц хугацааны өмнө хүрэлцэн ирэх үүрэгтэй.
11. Тээвэрлэгчийн төлөөлөгч болон ажилтан нь энэхүү гэрээний заалтыг өөрчлөх, хүчингүй болгох эрхгүй.

### ТЭЭШ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ ГАДААДЫН ЗОРЧИГЧДОД ӨГӨХ САНАМЖ

Зорчигч нь иргэний агаарын тээврийн үйлчилгээний тухай Варшавын конвенц болон Монреалийн конвенцийг мөрдлөг болгодог улс орон руу зорчих ба дайран өнгөрөх тохиолдолд аялалын туршид Варшавын конвенцийн нөхцлүүдийг дагаж мөрднө. Тээвэрлэгч болон гэрээнд оролцогч талуудын нэр бүх билетийн кассууд дээр тэмдэглэгдсэн байх ба зорчигчийн хүсэлтийн дагуу тээшээ асуун шалгаж болно. Зорчигч хувийн даатгалын компанид хандан тээшээ даатгуулж аюулгүй байдлыг давхар хангаж болно. Энэхүү даатгалд Варшавын конвенцийн тээш тээвэрлэлтийн хариуцлагыг хязгаарлах журам ямар нэг байдлаар нөлөөлөхгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг тээвэрлэгч болон даатгалын компаниасаа лавлана уу.

### ТЭЭВЭРЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ

Изинис Эйрвэйз компани нь дараах тохиолдолд зорчигчийг тээвэрлэлтэнд хүлээн авахаас татгалзах эрхтэй. Үүнд: 1. Нислэгийн аюулгүй ажиллагаа зорчигч нисэх баг, агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах үүднээс газрын үйлчилгээний ажилтан болон нисэх багийн гишүүний тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд 2. Архи, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн бол 3. Ажил үүргээ гүйцэтгэж байгаа ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК-ны ажилтныг заналхийлсэн, доромжилсон энэ үйлдэл нь даамжирч ажилтан болон зорчигчдийн ая тухтай байдлыг алдагдуулсан, гэмтэл хохирол учруулсан бол 4. Орон нутгийн нислэгт хүчин төгөлдөр иргэний үнэмлэх болон олон улсын нислэгт гадаад паспорт болон холбогдох визгүй бол 5. Зорчигч бүртгэлийн үйл ажиллагаанаас хоцорсон бол. Дээрх зорчигчийн буруутай үйлдлийн улмаас ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК тээвэрлэлтэнд хүлээн аваагүй тохиолдолд зорчигч худалдан авсан тийзний нөхцлийн дагуу холбогдох торгууль, хураамжийг төлнө.

### ТЭЭШ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ САНАМЖ

Үнэт зүйлсийг урьдчилан мэдэгдэж нэмэлт хураамж төлөлгөөгүйгээр тээвэрлэсэн тохиолдолд тээш саатах, үрэгдэх, гэмтэхтэй холбогдсон хариуцлагыг тээвэрлэгч хүлээхгүй. Зарим төрлийн үнэт зүйлийг өндөрөөр үнэлэхгүй байж болно. Тээвэрлэгч нь хэврэг болон түргэн мууддаг зүйлд хариуцлага хүлээхгүй. Нэмэлт зүйлийг тээвэрлэгч байгууллагаасаа асууна уу.

## **ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН НИСЭХ БУУДЛААС ТОГТООСОН ТАТВАР ХУРААМЖИЙН ТУХАЙ**

Засгийн газрын эрх бүхий байгууллага болон нисэх онгоцны буудлаас тогтоосон татвар хураамж тийзийн үнэнд орсон байж болно. Аяллын үнийн тодорхой хэсэг болох тэдгээр татвар хураамжуудыг тарифын дүнд оруулсан байж болохоос гадна тийзийн "TAX/FEE/CHARGE" гэсэн нүдэнд тусд нь бичсэн байж болно. Тийз худалдан авахад төлөгдөөгүй татвар хураамжуудыг төлөх шаардлага танд гарч болох юм.

### **НИСЛЭГТ АВЧ ЯВАХАД ХОРИТОЙ ЭД ЗҮЙЛС БОЛОН АЮУЛТАЙ БАРАА**

Нислэгийн аюулгүй байдлыг хангах үүднээс доор дурьдсан аюултай барааг зорчигчийн бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй (гар тээш) хэлбэрээр авч явахыг хориглоно.

Тэсэрч дэлбэрэх бодис (буудуулдаг салют г.м), шатамхай шингэн болон шатамхай хатуу бодис (их хэмжээний шүдэнз, асаагуур), спиртийн төрлийн ундаа (спиртийн хэмжээ \*70 процентоос их тохиолдолд), шахсан хий (бутаны хий болон спортын зориулалтын хүчилтөрөгч), хордуулагч бодис (шавьж устгагч бодис г.м), идэмхий бодис, цацраг идэвхит бодис, их хэмжээгээр соронзлогдсон материал, исэлдүүлэгч бодис, харшил үзүүлэгч бодис болон хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, агаарын хөлгийн аюулгүй байдалд хор хөнөөл учруулах бодисууд орно.

(\*) 1 зорчигчид 24-70 процентын 3 литр хүртэл спиртийн төрлийн ундаа тээвэрлүүлэхийг зөвшөөрнө.

Эмчилгээний болон ариун цэврийн гэх мэт бусад зүйлийг бага хэмжээгээр авч явахыг зөвшөөрнө.

Буу, сэлэм, хутга зэрэг зэвсэг, хурц үзүүртэй зүйлсийг онгоцны бүхээгт авч орохыг хатуу хориглоно. Бусад дэлгэрэнгүй мэдээллийг Та ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК-ийн лавлахаас асууна уу.

### **ТАНЫ АНХААРАЛД**

#### **АЯЛАЛЫН ТУХАЙ**

- Засгийн газраас тогтоосон журмын дагуу Таны аялалд хэрэглэх баримт бичгүүд, үүнд хүчинтэй паспорт болон иргэний үнэмлэх, шаардлагатай бол виз бүрдүүлж, дархлаажуулалтын үнэмлэхээ мартуузай.

- Зорчигч нислэг эхлэхээс 1 цаг 30 минутын өмнө /олон улсын нислэгт 2 цагийн өмнө/ тухайн нисэх буудалд хүрэлцэн ирж зорчигчийн тийз ба тээшийн бүртгэл болон паспортын шалгалтанд орох ёстой. Хэрэв зорчигч тогтоосон хугацааны өмнө нисэх буудалд хүрэлцэн ирж чадаагүйгээс эсвэл шаардлага хангахгүй баримт бичигтэй ирснээс захиалгат суудлаа ашиглаагүй тохиолдолд суудлын торгууль, үйлчилгээний хураамжийг зохих журмын дагуу төлнө.

**ЗАХИАЛГАА БАТАЛГААЖУУЛАХ /зөвхөн олон улсын нислэгт хамааралтай/:** Та дамжин өнгөрөх буюу очоод буцах газартаа 24 цагаас илүү хугацаагаар байх бол дамжин явах буюу буцах нислэгт захиалсан суудлаа нислэг эхлэхээс 24 цагийн өмнө баталгаажуулж байна уу. Дурдсан хугацаанд суудлаа баталгаажуулаагүй бол захиалга чинь хүчингүй болохыг анхаарна уу.

**ТИЙЗ БОЛОН МСО:** Тийз нь зорчигч тээвэрлэгч хоёрын хооронд байгуулсан тээвэрлэлтийн тухай гэрээ юм. Тийз болон МСО нь зөвхөн түүн дээр бичигдсэн нэр бүхий зорчигчийн хувьд л хүчин төгөлдөр байна. Бусад дамжуулсан эсвэл засварласан тийз болон МСО-г хүчингүйд тооцож тээвэрлэлтэнд хүлээн авахаас татгалзана.

**ТИЙЗ БОЛОН МСО-ИЙН ХҮЧИНТЭЙ БАЙХ НӨХЦӨЛ:** МСО болон үндсэн тарифийн тийзнээ хүчинтэй хугацаа нь тухайн худалдан авсан тарифийн нөхцлөөр хязгаарлагдана. Харин ямар нэг хөнгөлөлттэй эсвэл тусгай тарифаар бичигдсэн тийзийн хүчинтэй хугацаа тухайн тарифын нөхцөлд заасан журмаар хязгаарлагдах тул Та явах өдрөө буюу нислэгээ солих тохиолдолд тийзийнхээ хүчинтэй байх нөхцлийг шалгаж байна уу. Хэрэв эргэлзээ төрвөл уг тийзийг худалдаж авсан газраасаа асуугаарай.

**ТИЙЗ АШИГЛАХ ДАРААЛАЛ:** Нислэгийн тийзийг тийзэнд заасан эхний газраас эхлэн дарааллаар нь ашиглах ёстой.

#### **ЗАХИАЛГА, ЧИГЛЭЛ ӨӨРЧЛӨХ БОЛОН ТӨЛБӨР БУЦААХ:**

- Хэрэв зорчигч (групп зорчигчид мөн адил) аялал эхлэхээс өмнө нислэгийн өдөр, чиглэл өөрчлөх болон тийзээ буцаахыг хүссэн тохиолдолд зохих хэмжээний үйлчилгээний хураамж төлнө.

- Харин ямар нэг хөнгөлөлттэй эсвэл тусгай тарифаар бичигдсэн тийзийн хувьд захиалга болон аялал өөрчлөх, тийз буцаагдах боломжгүй байдаг тул ИЗИНИС ЭЙРВЭЙЗ компаний, эсвэл тийз авсан газраасаа лавлана уу.

**ГАР ТЭЭШ:** Зорчигчийн гар тээш нь онгоцны суудлын доор болон тээш хадгалах хэсэгт багтахар байх ба 5 кг-аас хэтрэхгүй байх ёстой. Гар тээшний 3 талын хэмжээсийн нийлбэр нь 105 см-ээс хэтэрч болохгүй. Өөрөөр хэлбэл гар тээшний 3 талын хэмжээс нь бариул, дугуй зэрэг нь ороод 23см x 34см x 48 см-ээс хэтрэхгүй байвал зохино.

**ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ТЭЭВЭРЛҮҮЛЖ БОЛОХ ТЭЭШ:** Та ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК-ийн орон нутгийн нислэгээр зорчихдоо худалдан авсан тарифийн нөхцөлд заасан тээшийг үнэ төлбөргүй тээвэрлүүлэх эрхтэй ба гурван талын нийлбэр хэмжээ нь 140 см-ээс хэтрэхгүй байх ёстой. Үнэ төлбөргүй тээвэрлүүлж болох хэмжээнээс хэтэрсэн тээшийг илүү жингийн нэгж тутамд тогтоосон тарифаар үнийг төлж зорчино. Тийз борлуулалтын ажилтанд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр зуны нислэгт 30 кг болон түүнээс дээш, өвлийн нислэгт 40 кг болон түүнээс дээш илүү тээшийг тээвэрлэлтэнд хүлээн авна. Урьдчилж мэдэгдээгүй тохиолдолд тухайн нислэгийн ачаалалтаас хамааран тээшийг дараагийн нислэгээр тээвэрлэж болно.

#### **ҮНЭТ БОЛОН ХЭВРЭГ ЗҮЙЛС:**

- Та мөнгө, үнэт эдлэл, компьютер, дижитал камер зэрэг эд зүйлсийг бүртгүүлэх тээшиндээ хийхгүй байхыг зөвлөж байна. Хэрэв тийм эд зүйлс чинь алдагдах буюу гэмтэх бол тээвэрлэгч ямарваа нэг хариуцлага хүлээхгүй болохыг анхаарна уу.

- ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК нь хөгжмийн зэмсэг, шилэн эдлэл, цаг, камер зэрэг хэврэг зүйлс гэмтсэн тохиолдолд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно.

- Хэт овортой болон хэт дүүргэж багласан тээш, хэт хуучин эсвэл чанар муутай чемоданы дугуй зэрэг хэсэг нь салсан, их бие болон бусад хэсгүүд гэмтэж зурагдсан, хонхойсон, бохирдсон зэрэгт ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК хариуцлага хүлээхгүй болно. Дэлгэрэнгүй мэдээллийг тийз авсан газар болон ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК-аас лавлана уу.

**Та аян замдаа сайн яваарай.**